



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 06/09

Улаан-уул

Г Хоршоо хөгжүүлэх сангийн талаар
авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Хоршооны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3, 3.3.1, 3.3.2, 3.3.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 6 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах хороог 1 дүгээр хавсралтаар, хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг 2 дугаар хавсралтаар, хоршоо хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэлийг 3 дугаар хавсралтаар, сангийн үйл ажиллагааны зардлыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийн дээд хэмжээг 50,000,000 (тавин сая) төгрөг байхаар тогтоосугай.


3. Хавсралтад дурдсан чиглэлийн хүрээнд төслийг сонгон шалгаруулж, эргэн төлөлтийг сайжруулж, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат)-д даалгасугай.

ДАРГА  С.ГОНГОР

Ёсчилсон 2022 оны 03 сарын 10 ны өдөр

D:\dok\ИТХ-8 дахь удаагийн сонгууль\6-р хуралдаан\тогтоол.docx

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
6 дугаар хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 10-ны
өдрийн 06/09 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт



ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга: Засаг даргын Тамгын газрын дарга М.Зоригт

Нарийн бичгийн дарга: Хоршоо, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн

Б.Азжаргал


Гишүүд: Хоршоо хариуцсан нягтлан бодогч Г.Очгэрэл

Банкны төлөөлөл Э.Ариунбилэг

Банкны төлөөлөл А.Мөнхцэцэг

---oOo---

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
6 дугаар хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 10-ны
өдрийн 06/09 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт



ХЯНАЛТ ТАВИХ ОРОН ТООНЫ БУС
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хяналтын зөвлөлийн дарга: Г.Нямдаваа

Нарийн бичгийн дарга: Хоршоо, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн

Б.Азжаргал

Гишүүд: Аймгийн хоршоо, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн


Б.Оюунцэцэг

Төрийн сангийн мэргэжилтэн Д.Сайханцэцэг

Банкны төлөөлөл Ш.Ариунжаргал

---oOo---

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
6 дугаар хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 10-ны
өдрийн 06/09 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт




ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

1. Гамшгийн нөөц бүрдүүлэх зорилгоор тэжээлийн ургамал тариалах
2. Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр, цех байгуулах
3. Зам дагуу үйлчилгээ явуулах /цайны газар, гуанз, дэлгүүр ажиллуулах/
4. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ /сувинер/

---oO---

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
6 дугаар хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 10-ны
өдрийн 06/09 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт



САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

- 1.Хяналтын зардалд 800,000 (найман зуун мянга) төгрөг
2. Төсөл хэрэгжүүлж байгаа иргэдэд мэдээлэл, сургалт хийх зардалд 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөг

---oOo---